

ХЯТАД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ШИНЭ HSK ШАЛГАЛТЫН АГУУЛГАД НИЙЦҮҮЛЭХ НЬ

В. БАТМАА*

Монгол, Хятад хоёр орны тал бүрийн харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжихийн хэрээр хятад хэл суралцагчдын тоо ихээр нэмэгдэж, хятад хэлний сургалт өргөжин боловсролын салбарт чухал гадаад хэлний нэг болж жинтэй байр суурь эзлэх болжээ. Хятад хэл сурах нийгмийн эрэлт хэрэгцээг даган сургалтыг сайжруулж олон улсын жишигт хүргэх, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай сайн боловсон хүчин бэлтгэж гаргах нь аливаа боловсролын байгууллагын эн тэргүүний чухал зорилт болоод байна. Манай орны боловсролын эрхзүйн орчинд сургалтын гол баримт бичиг болох сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийг сургууль өөрийн судалгаа – аргазүйн багт тулгуурлан боловсруулж мөрдлөгө болгодог. Бид өнөөгийн сургалтын шаардлагыг хангахуйц хэмжээний агуулгыг боловсруулжирсэн баялаг туршлагатай боловч дэлхий нийтийн боловсролын чиг хандлага, жишигт нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох нь чухал байна. Үүний тулд бид сургалтын хөтөлбөрийг хэлний түвшингийн хөтөлбөртэй нягт уялдуулах нь олон талын ач холбогдолтой гэж үзэж байна. Ялангуяа БНХАУ-д 2009 оноос батлан мөрдөж байгаа хятад хэлний түвшин тогтоох шалгалтын (HSK, 汉语水平考试 - үгсийн

товчлол) шинэ агуулгыг сургалтын хөтөлбөрт зайлшгүй тусгах шаардлага гарч байна. БНХАУ-ын Хятад хэлийг гадаадад түгээн дэлгэрүүлэх ажлыг удирдах улсын албанаас (国家汉办) дотоод болон гадаадад тогтмол явуулж, зохих сертификатыг олгодог HSK шалгалт нь дэлхий нийтээр нэгэнт хүлээн зөвшөөрсөн, нэр хүнд бүхий шалтгалт юм. Энэхүү шалгалтыг анх 1988 оноос авч эхэлсэн бөгөөд одоогоор дэлхийн 40 гаруй оронд эрх бүхий байгууллага тогтмол зохион явуулсаар ирсэн. Манай орны хувьд 2002 онд МУБИС, 2011 оноос МУИС-ийн Күнзийн Институт шалгалт зохион байгуулах албан ёсны эрхийг тус тус авснаар уг шалгалтыг улсын хэмжээнд жилд 2 удаа зохион байгуулж байна. 2011 оноос Монголд шинэ HSK шалгалтыг авч эхлээд байна.

HSK шалгалтын дүн нь сургуульд элсэх, анги хуваарилах, багц цаг дүйцүүлэн тооцох, ажилд авах, сургалтанд хамруулах, сургууль болон боловсролын байгууллагын сургалтанд үнэлгээ хийх зэрэгт харгалзаж үзэх чухал үндэслэл болохын зэрэгцээ суралцагч өөрийнхөө хэлний түвшинг тогтооход чухал ач холбогдолтой байдаг. HSK шалгалт нь хятад хэлний түвшинг суурь, анхан-дунд болон дээд шатны 11 зэргээр ангилан авч үздэг, хэлний бүтцийн асуудал ихээхэн

* В. БАТМАА - МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн багш, доктор (Ph.D)

орсон, учир зүйн ээдрээтэй асуулт цөөнгүй, нүсэр хэмжээтэй зэрэг суралцагчийн хэлний чадварыг бодитоор тогтооход учир дутагдалтай зэрэг сул талууд ажиглагддаг. Иймээс хятад хэлний сургалт, заах аргазүйн онцлог, хэл шинжлэл, сэтгэл судлал болон боловсрол судлалын талаар гадаад дотоодын олон эрдэмтдийн хийсэн судалгаанд суурилан гадаад орнуудын хятад хэлний сургалтын бодит байдлыг харгалзан, бусад орны хэлний шалгалт авах туршлагаас судалж, өмнөх HSK шалгалтын давуу талыг хадгалахын зэрэгцээ суралцагчийн хэлний чадварын түвшнийг тогтоохыг түлхүү анхаарч илүү прагматик шинжтэй болгон шинэчлэн боловсруулсан байна. Шинэ HSK шалгалт нь бүтэц, агуулга болон хэлбэрийн хувьд ихээхэн өөрчлөгдсөн. Тухайлбал, шалгалт бичгийн болон аман хоёр хэлбэртэй, бичгийн шалгалтыг хятад хэлний анхан, дунд болон дээд шатны 6 зэрэгт ангилсан, аман шалгалтыг анхан, дунд болон дээд гэсэн 3 түвшинд авч үзэх болжээ. Шинэ шалгалтаар тогтоосон хэлний түвшинг АНУ-ын Гадаад хэлний нийгэмлэгээс 2007 онд гаргасан "Хятад хэлний чадварын олон улсын стандарт" болон Кембрижийн Их Сургуулиас 2003 онд гаргасан "Хэлний түвшний бүх Европын харгалзах жишиг" (CEF—A Common European Framework Reference for Languages: learning, teaching, assesment)-тэй харьцуулан үзүүлбэл доорхи байдалтай байна.

Шинэ HSK	Хятад хэлний чадварын олон улсын стандарт	CEF
6-р зэрэг	5-р зэрэг	C2
5-р зэрэг		C1
4-р зэрэг	4-р зэрэг	B2

*HSK бичгийн шалгалтын тухайд

3-р зэрэг	3-р зэрэг	B1
2-р зэрэг	2-р зэрэг	A2
1-р зэрэг	1-р зэрэг	A1

Бүтцийн хувьд шинэ HSK* нь өмнөх шалгалтаас ихээхэн ялгаатай бөгөөд анхан шатны хэлний шалгалт (1-2-р зэрэг) нь сонсох болон унших чадварыг шалгах тус бүр 100 онооны 2 хэсгээс бүтнэ. Харин дунд (3-4-р зэрэг) болон дээд (5-6-р зэрэг) шатны шалгалт нь нийт 300 онооны сонсох, унших болон бичих гэсэн 3 хэсгээс бүтсэн байна. Үүнээс үзэхэд өмнөх HSK шалгалтын хэлзүйн бүтэц, үгийн сан зэрэг хэсэг хасагдаж хэлэхүйн үндсэн чадварыг тогтооход чиглэсэн цоо шинэ бүтэцтэй болжээ. Шинэ HSK шалгалт хэлбэрийн хувьд сонсох дасгал нь зурагтай ажиллах, бичих дадлын асуулт нь зургийн дагуу өгүүлбэр зохиох, зохион бичлэг бичих зэргээр шинэчлэгдсэн байна.

HSK шалгалтыг боловсруулах гол арга зүйн үндэс нь "Хятад хэлний түвшин, зэрэг тогтоох стандарт" (汉语水平等级标准) (хэлэхүйн чадвар, хэлний бүтэц болон харилцааны сэдвийг хэлний 3 түвшин 5 зэргээр эрэмбэлэн тодорхойлсон хөтөлбөр), "Хятад хэлний ханз үсэг болон үгийн санг түвшингээр ангилах хөтөлбөр" (汉语水平词汇与汉字等级大纲) (хятад хэлний түвшин бүрт зайлшгүй эзэмших ханз үсэг болон үгийн сангийн хөтөлбөр) болон "Хятад хэлний хэлзүйг түвшингээр ангилах хөтөлбөр" (汉语水平语法等级大纲) (хятад хэлний түвшин бүрт зайлшгүй эзэмших хэлзүйг тодорхойлсон хөтөлбөр) гэсэн үндсэн 3 хөтөлбөрт суурилсан байдаг бөгөөд эдгээр нь HSK шалгалтын гол агуулгыг тодорхойлдог. Дээрх 3 хөтөлбөрт тулгуурлан HSK шалгалтын

үгийн сан, хэлзүй болон хэлний үүргийг түвшин болон зэрэг тус бүрт тогтоосон байдаг. Түүнчлэн Хятадад албан ёсоор улсын хэмжээнд мөрдөж буй "Гадаад оюутанд зориулсан хятад хэлний мэргэжлийн сургалтын хөтөлбөр"-ийг ч мөн эдгээр баримт бичигт тулгуурлан боловсруулж хэлний түвшин бүрт зайлшгүй эзэмшвэл зохих ханз үсэг болон үгийг тоог орчин цагийн хятад хэлэнд хэрэглэгдэх үгийн давтамж дээр тулгуурлан тус бүр тогтоож заасан, хэлзүйн үндсэн тогтолцоо болон тусгайлаг хэлний онцлог болох хэвшмэл хэллэг буюу бүтцийг хэлний түвшингээр эрэмбэлэн тогтоосон байдаг. Тухайлбал "Хятад хэлний ханз үсэг болон үгийн санг түвшингээр ангилах хөтөлбөр" (汉语水平词汇与汉字等级大纲) -т эзэмшвэл зохих ханз үсэг болон үгийн санг хэлний түвшингээр эрэмбэлэн тогтоосныг тус сургуулийн 2011 онд батлан шинэчлэн мөрдөж буй хөтөлбөртэй харьцуулан үзвэл:

Хөтөлбөрт заасан зэрэг	Үгийн сан	Ханз үсэг	Гадаад хэл соёлын сургуулийн хөтөлбөрт заасан эзэмшвэл зохих үгийн сан (улирлаар)
А	1033	800	780
Б	2018	804	1500
В	2202	590+11	2200
Г	3569	670+30	3000-3500
нийт	8822	2905	

Эдгээр хөтөлбөрүүдэд заасан эзэмшвэл зохих үгийн сан болон ханз үсгийн тоо хэмжээ нь шинэ HSK шалгалтанд хэрхэн тусгагдсаныг тодруулан үзүүлбэл доорхи байдалтай байна. Үүнд:

Хэлний түвшин	HSK зэрэг	Үгийн сан	Хэлзүй

Анхан	1	150	А
	2	300	А, Б
Дунд	3	600	Б
	4	1200	В
Дээд	5	2500	В, Г
	6	5000-аас дээш	Г

Үүнээс үзэхэд МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн хятад хэлний ангийн оюутан 4 улирлын төгсгөлд хятад хэлний Б зэргийн үгийн сан эзэмшсэнээр шинэ HSK шалгалтын 4 зэрэг буюу хятад хэлний дунд шатны батламж авах бүрэн боломж байгаа нь харагдаж байна. Энэ нь сургалтын төлөвлөгөөнд эхний 4 улиралд судлан үзэх хэлний багц цагийг дорвитой нэмсэнтэй шууд холбоотой гэж үзэж байна. Ялангуяа 3, 4 дүгээр улирлуудад судлах нийт 12 багц цагийг 20 хүртэл нэмсэн нь оюутнуудын хэлний ерөнхий мэдлэг, хэлэхүйн чадварыг бодитой дээшлүүлэх үндсэн нөхцөл болсон нь дамжиггүй. Дээрх хүснэгтээс үзэхэд эзэмшвэл зохих хэлний нэгж болон хэлний тогтолцооны талаар эзэмшсэн мэдлэгийн хувьд тоон үзүүлгүүдэд тулгуурлан шинэ HSK шалгалтын 5 зэрэгт хүрэх боломжтой мэт харагдавч суралцагчийн хэлэхүйн бодит чадварыг дүгнэхэд дэндүү өрөөсгөл тул бид хятад хэлний дунд шатны 4 зэрэгт хүрэх боломжтой гэсэн дүгнэлт хийсэн. Шинэ HSK шалгалт нь илүү прагматик шинжтэй, бүтэц, хэлбэрийн хувьд суралцагчийн хэлний бодит чадваруудыг үнэлж дүгнэхийг онцгой анхаарч боловсруулсан болохыг дээр нэгэнт дурдсан билээ. Шалгалтын бүтэц болон агуулгын стандартыг харахад өмнөхөөсөө хялбар, түвшин доогуур болсон мэт (ялангуяа анхан шатны шалгалт) санагдавч нөгөө талаас

* Үүнд сургалтын төлөвлөгөөнд заасан ерөнхий хятад хэлний хичээлийг хамруулж байна

хэлэхүйн продуктив чадваруудыг түлхүү үнэлж суралцагчийн хэлний түвшинг илүү бодитой тогтоохыг зорьсон нь илт байна. Бид сургалтын үйл явцыг тогтмол хянах, үнэлэх, олон улсад хүлээн зөвшөөрсөн энэхүү HSK шалгалтын үнэлгээгээр дүнэхэд чухам ямар түвшинд зааж сургаж байгаагаа тодорхой тогтоох үүднээс оюутнуудаа тогтмол оролцуулах, тэдний үнэлгээнд дүн шинжилгээ хийж сургалтын хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаагаа үүнтэй уялдуулах шаардлага гарч байна. Бид сургалтын хөтөлбөрөө онол аргагүйн хувьд шинэчлэн боловсруулж сургалтын зорилго, зорилтыг зөв тодорхойлон оюутны хэлний мэдлэг болон хэлэхүйн чадварыг зохистой харьцаагаар үе шаттай хөгжүүлэх нь чухал байна. Тухайлбал, сургалтын хөтөлбөрийг юуны өмнө хятад хэлний түвшний хөтөлбөрүүд, түвшин тогтоох стандарттай нягт уялдуулах нь сургалтын зорилго, зорилтыг тодорхойлох, агуулгын стандарт тогтооход ихээхэн ач холбогдолтой байна. Үүнд "Хятад хэлний түвшин, зэрэг тогтоох стандарт" (汉语水平等级标准), "Хятад хэлний ханз үсэг болон үгийн санг түвшингээр ангилах хөтөлбөр" (汉语水平词汇与汉字等级大纲), "Хятад хэлний хэлзүйг түвшингээр ангилах хөтөлбөр" (汉语水平语法等级大纲) зэрэг хөтөлбөрүүдээс өөрийн сургуулийн сургалтын хөтөлбөрт тодорхой тусгах зайлшгүй шаардлага гарч байна. Ингэснээр бид сургалтанд нэгдсэн шаардлага тавьж, нэгдсэн стандартыг хангаж, хэлний нэгдсэн түвшин зэргийг тогтоох боломжтой болно. Түүнчлэн Хятадын их, дээд сургуулиудын хятад хэлний мэргэжлийн сургалтын туршлагыг судлан үзэж, шинэ HSK шалгалтын бүтэц, агуулгатай уялдуулан хэлний шат шатны сургалтанд хэлэхүйн

чадварууд эзэмшүүлэх хичээлийг зөв зохистой харьцаагаар зохион байгуулах нь нэн чухал байна. Тухайлбал, хятад хэлний анхан шатны буюу эхний 2 улирлын сургалтыг ерөнхий хятад хэлний (综合课) хичээл (10 цаг/7 хоног доошгүй) болон хэлэхүйн чадвар дагнан эзэмшүүлэх (单项技能课) сонсох ярих дадлын хичээл (10 цаг/7 хоног) гэж зохион байгуулан шинэ HSK шалгалтын бүтэц, агуулгад нийцүүлснээр анхан шатны 4 зэрэгт хүрэх боломжийг бүрдүүлнэ. Дунд түвшний буюу 3-4 улирлын хэлний сургалтыг ерөнхий хэлний хичээл (10 цаг/7 хоног доошгүй), сонсох ярих дадал (4-6 цаг/7хоног), унших бичих дадал (4 цаг/7 хоног)-ын хичээлүүд зохион байгуулснаар шинэ HSK шалгалтын 5 зэрэгт хүрэх боломжтой болно. Хичээлийг ийнхүү зохион байгуулж үр дүнтэй явуулахад тохирсон сурах бичгийг сонгох нь нэн чухал юм. Хятадын их дээд сургуулиудаас гаргасан хэлэхүйн чадвараар төрөлжүүлсэн цогц сурах бичгийг (配套教材) шууд авч хэрэглэхэд бас учир дутагдалтай нь ажиглагддаг. Үүний гол шалтгаан нь сургалтын төлөвлөгөөнд заасан багц цагийн ихээхэн зөрүүтэй байдал юм. Иймээс бид өөрсдийн нөхцөл байдалд тохирсон, сургалтын хөтөлбөртөө нийцсэн сурах бичгийг сонгож сургалтыг зохион байгуулах нь чухал байна.

HSK шалгалтын үнэлгээний өөр нэг ач холбогдолтой тал нь бакалаврын түвшний сургалтын дараа Хятадын их дээд сургуулиудад үргэлжлүүлэн ахисан түвшний сургалт, өөр мэргэжлийн бакалаврын сургалтанд суралцах, дотоод гадаадын байгууллага, албан газарт мэргэжлээрээ ажилд орох зэрэг тохиолдолд HSK шалгалтын дүнд үндэслэн тогтоосон хэлний түвшин, зэргийг гол шалгуур

шаардлага буюу харгалзах үзүүлэлт болгон нэгэнт авч үздэг болжээ. Тухайлбал, байгалийн шинжлэх ухаан болон инженерийн чиглэлийн мэргэжлээр Хятадын их дээд сургуульд элсэн суралцах тохиолдолд сургуулиудын тавих шаардлага, шалгуур нь хэдийгээр өөр байх боловч ерөнхийдөө шинэ HSK шалгалтын дунд түвшний 4 зэрэгт хүрсэн байх нийтлэг шаардлага тавьдаг. Харин хүмүүнлэгийн чиглэлийн мэргэжлээр сурах, ажилд орох тохиолдолд шинэ HSK шалгалтын дээд түвшний 5 зэрэгт хүрсэн байх нийтдэг

шаардлага байдаг. Иймээс энэхүү шалгуурт нийцсэн, өрсөлдөх чадвар бүхий боловсон хүчнийг бэлтгэн гаргаж, сургалтын гол зорилгод хүрэхэд суралцагчид болон зааж сургах багш хүн хоёул ямар зорилгоор хятад хэлийг хэдий хугацаанд сурч чухам ямар түвшинд хүрч ямар мэдлэг чадварыг эзэмшсэн байхаа сургалтын эхний үе шатаас эхлэн тодорхой мэддэг, сургалтын бүхий л үйл ажиллагаа, сургалтын аргазүй, сурах орчин үүнд чиглэхийн зэрэгцээ сургалтын үе шат бүрийг үнэлж дүгнэсэн цогц үйл явц байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Монгол Улсын боловсролын салбарын бодлого, 2007
2. Лувсандорж Ц. Киррикулим хөгжил ба боловсролын стандарт, 2006
3. Батмаа В. Хятад хэлний сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргазүйн асуудалд, 2008
4. Г. Цогзолмаа. 蒙古国HSK考试现状分析, 2010
5. 对外汉语教学: 思考与回眸, 2000
6. 对外汉语教学回顾与展望, 2010
7. 刘振卫。欧洲语言共同参考框架对我国制定统一的英语能力标准的启示, 2010
8. 美国外语教学“5C”标准与国际汉语能力标准的比较, 2011
9. 梁建国。汉语教学与汉语水平等级标准, 2011
10. 盛炎。汉语水平等级标准和等级大纲(试行)与国外一些标准和大纲的比较, 2011
11. 汉语水平等级标准, 2009
12. 汉语水平词汇与汉字等级大纲, 2009
13. 汉语水平语法等级大纲, 2009
14. 高等学校外国留学生汉语专业教学大纲, 2001
15. 新汉语水平考试大纲(3、4、5、6级), 2009